



GENCO TOUR
BUREAU JSC



2020

ЖЕНКОТУР БЮРО
ХУВЬЦААТ КОМПАНИ
ЖИЛИЙН ТАЙЛАН



КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

01

03-08

- 1.1. Компанийн танилцуулга
- 1.2. Засаглал
- 1.3. Танилцуулга

БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

02

09-20

- 2.1. Аялал жуулчлалын салбарын мэдээлэл
- 2.2. Бүтээгдэхүүн үйлчилгээ

2020 ОНЫ **ТАЙЛАН** 2021 ОНЫ **ТӨЛӨВЛӨГӨӨ**

03

21-28

- 3.1. Санхүүгийн тайлан
2021 оны төлөвлөгөө
- 3.2. Үйл ажиллагааны тайлан
2021 оны төлөвлөгөө
- 3.3. Аудитын дүгнэлт



КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА



Компанийн оноосон нэр:

Женкотур бюро ХК

Үйл ажиллагааны чиглэл:

Аялал жуулчлал, Гадаад худалдаа, Хүнс ахуйн хэрэглээний барааны худалдаа, Бэлэг дурсгалын худалдаа

Бүтээгдэхүүн үйлчилгээ:

- Аялал
 - Дотоод аялал (Inbound)
 - Гадаад аялал (Outbound)
 - Бүх төрлийн тээврийн билет захиалга
 - Зочид буудлын өрөө захиалга
 - Гэр жуулчны бааз захиалга
 - Уламжлалт баяр наадам зохион байгуулах
 - Хурал, семинар зохион байгуулах
- Чингис хааны морьт хөшөө цогцолбор
 - Үзвэр үйлчилгээ
 - Түрээсийн үйлчилгээ
 - Кофе шоп
 - Ресторан
- 13-р зуун цогцолбор
 - Үзвэр үйлчилгээ
 - Гэр жуулчны бааз
 - Ресторан
- Бэлэг дурсгалын худалдаа

Эрхэм зорилго:

Гадаад дотоодын жуулчдын эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцсэн чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэн, олон улсын түвшинд үнэлэгдэх үндэсний тур оператор компани болох.

Бидний уриа:

Тухлах газрыг Та сонго Туулах замыг бид хөтөлье

Үүсгэн байгуулагдсан огноо:

1997 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 01 сарын 11-ний өдрийн 05 тоот тогтоолоор Хувьцаат Компани болж өөрчлөгдөн зохион байгуулагдсан.

Компанийн удирдлага:

ТУЗ-ын дарга **Д.БАТЖАРГАЛ**
Гүйцэтгэх захирал **Б.НАМУУН**

Компанийн албан ёсны хаяг:

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө-5, Баянгол зочид буудал, оффис-4, ЗИП код: 14251

Утас: 7012 0202


И-мэйл: info@genco-tour.mn

Веб хуудас: www.genco-tour.mn

Фэйсбүүк: Genco Tour Bureau




“ЖЕНКОТУР БЮРО” ХК-ИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Энэхүү мэдээллийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аас 2020 оны 3-р сарын 27-ний өдрийн байдлаар авсан тархалтын судалгаанаас харахад хувьцаа эзэмшигчдийн бүтэц дараах байдалтай байна.

НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ТОО: 51 876



- 1,000,000 дээш хувьцаа эзэмшигчид - 86.10%
- 100,000-999,999 хувьцаа эзэмшигчид - 5.44%
- 10,000-99,999 хувьцаа эзэмшигчид - 4.58%
- 1-9999 хувьцаа эзэмшигчид - 3.88%



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА

ЕРДИЙН ГИШҮҮД



Нарангэрэл
БАТГЭРЭЛ

- ТУЗ-н Ердийн гишүүн
- “БиДиСЕК ҮЦК” ХК-ны Дэд захирал



Дорлигжав
БАТЖАРГАЛ

- ТУЗ-н дарга, Ердийн гишүүн
- СЭЗИСургуулийн ХАБХХ-ийн захирал



Данзан
ДАЯНБИЛГҮҮН

- ТУЗ-н Ердийн гишүүн
- “БиДиСЕК ҮЦК” ХК-ны Гүйцэтгэх захирал



Цэнд
ЭНХСАЙХАН

- ТУЗ-н Ердийн гишүүн
- “Женкотур Бюро” ХК-ны Гүйцэтгэх захирал



Баттулга
НАМУУН

- ТУЗ-н Ердийн гишүүн
- “Женкотур бюро” ХК-ны гүйцэтгэх захирал



Бүрэнмэнд
ЛХАГВАДОРЖ

- ТУЗ-н Ердийн гишүүн
- “БиДиСЕК ҮЦК” ХК-ны Тэргүүн дэд захирал

ХАРААТ БУС ГИШҮҮД



ҮҮРЦАЙХ
ТЭМҮҮЖИН

- ТУЗ-н Хараат бус гишүүн
- Нэр дэвшүүлэх хороо, цалин урамшууллын хорооны гишүүн, “Улаанбаатар секьюрити” ХХК-ны захирал



Баярсайхан
АЛТАНСУВД

- ТУЗ-н Хараат бус гишүүн
- Аудитын хороо, Цалин урамшууллын хорооны гишүүн
- “Файнаншил Про Аудит” ХХК-ны Гүйцэтгэх захирал



Ганболд
ӨСӨХБАЯР

- ТУЗ-н Хараат бус гишүүн
- Монгол банк Хянан шалгагч

ТУЗ-ийн ТАЙЛАН

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2020 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар сонгогдсон бөгөөд Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр олгосон бүрэн эрхийн хүрээнд тасралтгүй үйл ажиллагаа явуулж ирсэн ба өөрийн биеэр болон эчнээ санал хураалтаар нийт 12 хурал зохион байгуулж компанийн улирал бүрийн үйл ажиллагаа, төлөвлөгөөтэй танилцан холбогдох шийдвэр, зөвлөмжийг өгч ажилласан болно.

ТУЗ-ийн бүрэлдэхүүн:

ТУЗ-ийн дарга: Д.Батжаргал

ТУЗ-ийн ердийн гишүүд: Б.Лхагвадорж, Д.Даянбилгүүн, Ц.Энхсайхан, Б.Намуун, Н.Батгэрэл

ТУЗ-ийн хараат бус гишүүд: Б.Алтансүвд, Ү.Тэмүүжин, Г.Өсөхбаяр

ТУЗ-ийн дэргэдэх хороод:

Аудитын хороо: Б.Алтансүвд, Г.Өсөхбаяр, Б.Лхагвадорж

Нэр дэвшүүлэх хороо: Н.Батгэрэл, Ү.Тэмүүжин, Г.Өсөхбаяр

Цалин урамшууллын хороо: Б.Намуун, Б.Алтансүвд, Ү.Тэмүүжин





БИДНИЙ
ҮЙЛ АЖИЛЛАГАА

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР

ОЛОН УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР

2020 онд дэлхийн аялал жуулчлалын салбар корона вирусын халдвараас шалтгаалан нийт аялагчдын тоо 850 саяас 1,1 тэрбум – аар буурсан үзүүлэлттэй гарч дунджаар -72% - ын уналттай байхад зүүн өмнөд азийн уналт нь – 82% байжээ. Үүнээс 4-р сард -97% буюу хамгийн ихээр буурсан байна. Түүнчлэн 100-120 сая ажлын байранд эрсдэл учраад байна.




International Tourism and COVID-19

- Loss of 850 million to 1.1 billion international tourists
- Loss of US\$ 910 billion to US\$ 1.2 trillion in export revenues from tourism
- 100 to 120 million jobs at risk

Travel restrictions continue to weigh on the recovery

International Tourist Arrivals, monthly change (%), by region



МОНГОЛ УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас шинэ төрлийн корона вирус маш хурдацтай тархаж байгаа явдал онцгой анхаарал хандуулах зөвлөмж өгсөнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдаанаас “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай хэлэлцээр”-ийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасны дагуу монгол, хятадын хилийн боомтуудаар нэвтрэх иргэдийн хөдөлгөөнд 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл дараах хязгаарлалтыг хийхээр шийдвэрлэв.

Дээрхийн улмаас аялал жуулчлалын салбар 14 сарын турш тэг зогсолт хийгээд байна.

БОАЖЯ-аас мэдээлснээр

Аялал жуулчлал "0" ЗОГСОЛТ

Коронавирус

Аялал жуулчлалын салбарын нийт ажлын байранд 90%-т нөлөөлжээ.


- 1 Зочид буудал, дэн буудал
- 2 Амралтын газар, жуулчны бааз, гэр буудал
- 3 Ресторан, кофе шоп, поуж, баар
- 4 Музей, театр, үзэсгэлэн, бусад үйлчилгээний газар
- 5 Жуулчны тээвэр болон сувенир, бэлэг дурсгалын үйлдвэр эрхлэгчид

Нийт 88 000 ажлын байр эрсдэлд орсон

БҮТЭЭГДЭХҮҮН




ЧИНГИС ХААНЫ
МОРЬТ ХӨШӨӨ ЦОГЦОЛБОР



ХИИ ЗУУН ЦОГЦОЛБОР



ГАДААД АЯЛАЛ



ДОТООД АЯЛАЛ



БЭЛЭГ ДУРСГАЛ



2020 ОНЫ ТАЙЛАН

2020 САНХҮҮ ТАЙЛАН

2021 САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ҮЗҮҮЛЭЛТ	2019 он гүйцэтгэл /мян.төгрөгөөр/	2020 он төлөвлөгөө /мян.төгрөгөөр/	2020 он гүйцэтгэл /мян.төгрөгөөр//	2021 он төлөвлөгөө /мян.төгрөгөөр/
Борлуулалтын орлого	4,702,205	1,181,686	566,869	2,823,011
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	2,864,800	719,507	1,151,099	1,718,879
Нийт ашиг	1,837,405	462,179	(584,230)	1,104,132
Санхүү ба бусад орлого	2,813		38,745	
Үйл ажиллагааны зардал	400,974	163,473	363,120	265,412
Бусад зардал	41,625		52,886	
Бусад олз, гарз	247		10,323	
Татварын өмнөх ашиг	1,397,866	117,010	(951,168)	838,720
Орлогын татварын зардал	144,088		1,068	83,872
Тайлант жилийн цэвэр ашиг	1,253,778	117,010	(952,236)	754,848



2020 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Хөл хорионы үеээс бусад үеүүдэд Чингис Хааны Морьт Хөшөө цогцолбор, XIII зуун цогцолбор болон гадаад, дотоод аяллын бүтээгдэхүүнүүдийн борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор бүтээгдэхүүнээ хөгжүүлэх, нэр төрлийг нэмэгдүүлэх, тогтмолжуулах, ашиг орлогоо өсгөхийг зорилго болгон ажиллаа.

ТУСГАЙ АРГА ХЭМЖЭЭ


Солирын бороо



2020/08/15



Монгол бичгийн өдөрлөг



2020/09/12



Галын тахилга




2020/10/10



Нууц нүүдэлчид



2020/09/12



Морин цирк

2020/09/12



ЦОГЦОЛБОРУУД

ЦОГЦОЛБОРУУДЫН ТОХИЖИЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ТАЛААР

2020 оны төлөвлөгөө зорилтын хүрээнд өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан дараах тохижилт техник угсралтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 2020 онд үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, үйлчилгээний чанар, өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор тодорхой бүтээн байгуулалтын ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

ТОХИЖИЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД:

ЧИНГИС ХААНЫ МОРЬТ ХӨШӨӨТ ЦОГЦОЛБОР

1. Музей

21 зууны энэхүү дижитал эрин үед техник технологи хөгжиж музейн хэвээ маягаа өөрчлөх зайлшгүй шаардлагын үүднээс цогцолборын үзэл санаа, агуулгад тохирсон орчин үеийн шинэлэг хэлбэрийн музей бий болгох чиглэлээр ажиллаж, багаггүй ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Тун удахгүй музейн нээлт маань болж шинэ дүр төрхтэйгээр та бүхэнтэйгээ уулзах болно.

2. Ресторан

Үйлчлүүлэгчдийн тавтай тухтай орчныг бүрдүүлэх, сэтгэл ханамжийг дээшлүүлэх үүднээс ЧМХЦ-т байрлах “Алтан ташуур” ресторанд дотоод тохижилтын ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

3. Зүлэгжүүлэлт

Байгальд ээлтэй ногоон орчин бүрдүүлэх, өнгө үзэмжийг сайжруулах чиглэлийн хүрээнд цогцолборуудын ойрд орчмыг зүлэгжүүлэх ажил хийгдсэн.

4. Кофе шоп

Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, ашиг орлого нэмэгдүүлэх зорилгоор үйлчлүүлэгчдэд зориулсан кофе шоп-ын үйл ажиллагаа явуулах боломжтой боллоо.

5. Дотор дулаалга, дээвэр

Цогцолборын насжилтыг уртасгах, дулаан алдагдлыг багасгах, тав тухтай орчин бүрдүүлэх үүднээс засварын ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

6. Шат

Цогцолборын өнгө үзэм, аюулгүй байдлын сайжруулах чиглээр хийсдсэн томоохон ажлын нэг бол шатны бүрэн шинэчлэл байсан ба

13-Р ЗУУН ЦОГЦОЛБОР

Од дурандах үйлчилгээ

Үйлчлүүлэгчдийг татах, ашиг орлого нэмэгдүүлэх үүднээс од харах үйлчилгээг шинээр нэвтрүүлэв.



ЦОГЦОЛБОРУУД

МУЗЕЙ



РЕСТОРАН



ДОТОР ДУЛААЛГА



ЦОГЦОЛБОРУУД

ШАТ



КОФЕ ШОП



АЯЛЛУУД

ГАДААД АЯЛАЛ

2020 онд хөл хорионоос бусад үеүүдэд Азийн орнуудад аялал амжилттай зохион байгуулсан болно.



ДОТООД АЯЛАЛ

2020 онд хөл хорионоос бусад үеүүдэд дотоодын аялалыг өөрсдийн цогцолборуудыг түшиглэн амжилттай зохион байгуулсан.



2021 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл болон гадаад, дотоод орчин нэн ялангуяа Covid-19 вирусын аялал жуулчлалын салбарт үзүүлэх нөлөөллүүдийг үндэслэн **орлогоо тогворжуулж зардлаа хэмнэх үндсэн зорилготойгоор бүтээгдэхүүн хөгжүүлэлт, ажилтнуудын ур чадварыг сайжруулах, маркетингийн оновчтой бодлогуудыг хэрэгжүүлэх** дээр анхаарч 52 бүлэг 161 ажлуудыг төлөвлөн ажиллаж байна.

ГОЛЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

- Үндсэн болон туслах бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ зах зээлд нэвтрүүлэх.
- Тусгай хөтөлбөртэй үйл ажиллагаа (Event) зохион байгуулах.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд ахмадуудад чиглэсэн “Гэрэлт түүх”, хүүхдүүдэд чиглэсэн “Гэрэлт ирээдүй” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.
- Одоогийн вэбсайт (цахим хуудас) орчин үеийн чиг хандлагын дагуу хөгжүүлж шууд борлуулалт хийх боломжтой болгох, бусад төхөөрөмжүүдэд ашиглах боломжтой болгож Аппликешн нэвтрүүлэх.
- Олон улсын зах зээл дээрх харилцагчдын тоо, борлуулалтын сувгуудыг нэмэгдүүлэх.
- Цогцолборуудыг бүтээн байгуулах, үйл ажиллагааг эхлүүлэх үндсэн зорилго бүхий анхны төслүүдийг шинэчлэн сайжруулж хэрэгжүүлэх.
- Дотоод, гадаад аяллууд зохион байгуулах.
- Ажилтнуудын ур чадваруудыг сайжруулах сургалт хөгжлийн ажлуудыг хэрэгжүүлэх.
- Ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийг урьдчилан сэргийлэх ажлуудыг хэрэгжүүлэх.
- Үр дүнд суурилсан цалингийн бодлогыг сайжруулж хэрэгжүүлэх.
- ХАБЭХ-н үйл ажиллагаануудыг тогтмол зохион байгуулж сайжруулах.
- Чингис Хааны Морьт Хөшөөний сувинерын шинэ бүтээгдэхүүн гаргах.



САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ХАРААТ БУС АУДИТЫН ДҮГНЭЛТ



ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК

БАТАЛГААЖУУЛАЛТ, АУДИТ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Огноо 2021.03.15

№ 1/029

Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“Женкотур бюро” ХК-ийн Хувьцаа эзэмшигчид

Аудитын дүгнэлт

Бид “Женкотур бюро” ХК-ийн (“Компани” гэх)-ийн дараах тайлангуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ:

- 2020 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан;
- Энэ өдрөөр тасалбар болсон жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд; болон
- Нягтлан бодох бүртгэлийг томоохон бодлогуудын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь Компанийн 2020 оны 12-р сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаараа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)–ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (“АОУС”)–ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НБЭЗОУСЗ”)–ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол улсад мөрдүүлэхээр шаардлаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус байсан бөгөөд НБЭЗОУСЗ–ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан санал дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж бид найдаж байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант жилийн Компанийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй гэж мэргэжлийн шийдлээр бидний авч үзсэн асуудлууд болно. Гол асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудитын дүгнэлтээ илэрхийлэхдээ авч үзсэн бөгөөд эдгээр гол асуудлуудын талаар тусад нь дүгнэлт илэрхийлэхгүй.

Өмч, барилга, тоног төхөөрөмжийн дансны үнэ ба үнэ цэнийн бууралт

Компанийн санхүүгийн тайланд 8,388,015 мянган төгрөгийн дансны үнэ бүхий өмч барилга, тоног төхөөрөмжийн хүлээн зөвшөөрөлт болон хэмжилт нь шийдлийг удирдлагаас шаарддаг. Компанийн хөрөнгийн ашиглалттай холбоотой үнэ цэн бууралтын нөөцийг тодорхойлохтой холбоотой шийдлүүд гаргадаг.

Аудитын хариу

Бид 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх компанийн гүйцэтгэсэн үнэ цэнийн бууралтын тестийг шалгасан. Үнэ цэнийн бууралтын тестэд удирдлагын ашигласан өгөгдлүүд, мэргэжлийн ур чадвар болон бодитой байдлыг үнэлсэн. Мөн өмч, барилга, тоног төхөөрөмжтэй холбоотой үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрхийлсэн аливаа зүйл байхгүй талаарх удирдлагын үнэлгээг чухалчлан авч үзсэн.

3

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээдэг. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон бидний аудиторын тайлан ордоггүй. Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттайгаа холбогдуулан бидний хүлээх үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, ингэснээр бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитаар олж авсан бидний мэдлэг эсвэл өөр хэлбэрээр материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болох эсэх тухай материаллаг үл нийцлийг авч үзэхэд оршдог.

Бид өөрсдийн гүйцэтгэсэн ажил дээрээ суурилан энэхүү бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэлтэй байна гэж дүгнэвэл тухайн бодит байдлыг тайлагнахыг биднээс шаарддаг. Бидэнд ингэж тайлагнах зүйл байхгүй болно.

Санхүүгийн тайланд Удирдлага ба Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, болон алдаа юм уу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Санхүүгийн тайланг бэлтгэж байхдаа удирдлага нь компанийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага өөдрөг төсөөллөөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх компанийн чадамжийг үнэлж, шаардлагатай бол өөдрөг төсөөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан болох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ.

Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Заль мэх эсвэл алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажилтыг олж авч, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлж байна гэж амласан баталгаа гаргадаггүй.

Алдаа зөрчил нь заль мэхнээс эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд хэрэв тэр нь дангаараа эсвэл нийлэхээрээ санхүүгийн тайланд үндэслэн түүнийг хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг

хариуцлага


АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоо дээр үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 95.1-р зүйлд заасан дагуу зөвхөн “Женкотур бюро” ХК-ийн хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулахад зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



Эс Жи Эм Ди Аудит ХХК
Монгол улс, Улаанбаатар хот

Огноо: 2021.03.15

СБД 8-р хороо, Оюутны гудамж 14/2и байр 9 тоот

“ЖЕНКОТУР БЮРО”

Хувьцаат Компани

2020 оны 12 сарын 31-ний өдрөөрх САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тэм	2020 оны 12 сарын 31 мян.төг	2019 оны 12 сарын 31 мян.төг
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн бус хөрөнгө			
Өмч, барилга, тоног төхөөрөмж	9	8,388,015	8,638,126
Биет бус хөрөнгө	10	311,320	377,745
Биологийн хөрөнгө	11	63,190	87,830
Нийт эргэлтийн бус хөрөнгө		8,762,525	9,103,701
Эргэлтийн хөрөнгө			
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	12	272,402	254,831
Бараа материал	13	286,159	214,176
Худалдааны ба бусад авлага	14	361,369	349,020
Татварын авлага	15	55,331	4,655
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	16	30,182	563,395
Нийт эргэлтийн хөрөнгө		1,005,443	1,386,077
НИЙТ ХӨРӨНГӨ		9,767,968	10,489,778
ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР			
Өмч			
Хувьцаат капитал	17	7,998,880	7,998,880
Нэмж төлөгдсөн капитал		209,680	209,680
Дахин үнэлгээний нөөц		706,061	706,061
Хуримтлагдсан ашиг		134,717	1,166,647
Нийт өмч		9,049,338	10,081,268
Өр төлбөр			
Худалдааны ба бусад өглөг	18	544,359	383,428
Татварын өглөг	19	148,529	25,082
Бусад өглөг	20	14,585	-
Бусад нөөц	21	11,157	-
Нийт өр төлбөр		718,630	408,510
НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР		9,767,968	10,489,778

10-25-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салиггүй хэсэг болно.

“ЖЕНКОТУР БЮРО”
Хувьцаат Компани

2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН
ТАЙЛАН

	Тэм	2020 он мян.төг	2019 он мян.төг
Орлого	3	566,869	4,702,206
Борлуулалтын өртөг	3	(1,151,099)	(2,864,800)
Нийт ашиг		(584,230)	1,837,406
Хүүгийн болон бусад орлого	4	38,745	2,813
Ерөнхий удирдлагын зардал	5	(363,120)	(400,974)
Бусад зардал	6	(52,886)	(41,626)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	7	10,323	247
Татварын өмнөх ашиг		(951,168)	1,397,866
Татварын зардал	8	(1,068)	(144,088)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(952,236)	1,253,778
		(952,236)	1,253,778

“ЖЕНКОТУР БЮРО”
Хувьцаат Компани

**2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛГИЙН ТАЙЛАН**

	Хувьцаат капитал мян.төг	Нэмж төлөгдсөн капитал мян.төг	Дахин үнзлэгээний нөөц мян.төг	Хуримтлагдсан ашиг мян.төг	НИЙТ мян.төг
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	7,998,880	209,680	706,061	(322,586)	8,592,036
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	1,253,778	1,253,778
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	235,455	235,455
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	7,998,880	209,680	706,061	1,166,647	10,081,268
Нягтлан бодох бүртгэлийн боллогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(25,320)	(25,320)
Залруулсан үлдэгдэл	7,998,880	209,680	706,061	1,141,326	10,055,948
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(952,236)	(952,236)
Зарласан ногдол ашиг	-	-	-	(54,373)	(54,373)
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	7,998,880	209,680	706,061	134,717	9,049,338

10-25-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

**“ЖЕНКОТУР БЮРО”
Хувьцаат Компани**

**2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

	2020 он мян.төг	2019 он мян.төг
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	820,937	5,413,155
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	820,937	5,030,619
Бусад мөнгөн орлого	-	382,536
Мөнгөн зарлагын дүн	1,466,682	4,332,184
Ажиллагчдад төлсөн	308,623	384,822
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	24,559	119,492
Бараа материал худалдан авахад төлсөн	970,056	2,922,114
Ашиглалтын зардалд төлсөн	-	89,271
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,707	42,472
Хүүний төлбөрт төлсөн	-	63,215
Татварын байгууллагад төлсөн	51,347	601,702
Даатгалын төлбөрт төлсөн	-	1,500
Бусад мөнгөн зарлага	110,391	107,596
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(645,745)	1,080,971
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	10,682	15,073
Хүлээн авсан хүүний орлого	10,682	2,073
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		13,000
Мөнгөн зарлагын дүн (-)	4,441	56,071
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,441	56,071
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	6,241	(40,999)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	113,250	3,433
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	112,207	-
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	1,043	3,433
Мөнгөн зарлагын дүн (-)	6,959	619,425
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	6,938	618,523
Бусад	21	902
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал		
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	106,292	(615,991)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(533,213)	423,982
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	563,395	139,413
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	30,182	563,395



**GENCO TOUR
BUREAU JSC**

2021 он